



АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3. Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23. № 3/320.

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Анагаах ухааны хүрээлэн УТҮГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Анагаах ухааны хүрээлэн УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0223\AG26.Docx

УХА0122



**“АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” УТҮГ-ЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46, Бага тойруу 6

АУДИТЫН ТАЙЛАН

Web: www.audit.mn

YAG Санхүүгийн аудитын газрын
захирал: Ц.Наранчимэг

Утас: 261663

И-мэйл: naranchimeg.ts@audit.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 99117703

И-мэйл: sambuunyam.ya@audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК

Утас: 70001778

Web: www.imkaudit.mn

Захирал: С.Тунгалаг

Утас: 99061771

И-мэйл: tungalag.s@imkaudit.mn

Аудитын менежер

Аудитор: Г.Ариунбат

Утас: 88182081

И-мэйл: ariunbat.g@imkaudit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТЫН КОД:
САГ-2017/350/СТА-ТШЗ

Агуулга

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин	4
Гурав. Байгууллагын зорилго үйл ажиллагаа	4
Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн	5
Тав. Материаллаг байдал:	6
Зургаа. Дотоод хяналт:	6
Долоо. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:	6
Найм. Шилэн дансны мэдээлэл:	6
Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд:	7
Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:	7
Арван нэг. Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:	7
Арван хоёр. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:	7
Арван дөрөв. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:	10
Арван тав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:	11
Арван зургаа. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	11
Арван долоо. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:	11
Арван найм. Зөвлөмж	11
Арван ес. Зөрчилгүй санал дүгнэлт	11

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд “Ихмонгол хөлөг Аудит” ХХК аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, журам, бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ нь санхүүгийн тайлангаа Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-д нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны завсрын болон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд эхэлж 2017 оны 2 дугаар сарын 15 -ны хооронд хийхээр төлөвлөн “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8.9.1-д заасан төсвийн цаглабарт заасан хугацаанд буюу 2017 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн.

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ нь дараахь хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2010 оны 36 дугаар тогтоол зэрэг байна.
- НБББББичиг /2014 он/

Гурав. Байгууллагын зорилго үйл ажиллагаа

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ нь БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1961 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн зарлигаар Шинжлэх Ухааны Академийн 5 хүрээлэн байгуулсны нэг нь “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ юм. “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ нь Нийгмийн эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын сектор, Мэс заслын сектор, Дотор өвчин судлалын сектор, Хүүхэд, эмэгтэйчүүдийн сектор, Хоол судлалын сектор, халдварт өвчин, халдвар судлалын сектор гэсэн 6 секторын бүтэцтэй байгуулагдсан.

Одоо тус байгууллага 46 ажиллагсадтай үйл ажиллагаагаа эрхлэж байна. Хүрээлэнгийн анхны захирлаар Түндэвийн Шагдарсүрэн ажилласан бөгөөд түүний 80 насны ойг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит болгож дурсгалыг нь мөнхжүүлсэн түүхтэй. МУ-ын Засгийн Газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ыг анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяанд шилжүүлсэн.

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын эрхэм зорилго нь: Анагаахын шинжлэх ухаан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөгжлийн ерөнхий хандлага, өнөөгийн түвшин, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээ, сургалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогц нэгдлийг хангасан, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай шилдэг судлаачдаас бүрдсэн Монгол Улсын эмнэл зүйн анагаах ухааны тэргүүлэх эрдэм шинжилгээний байгууллага байна гэж тодорхойлсон байна.

Үндсэн чиг үүрэг нь: Анагаах ухааны эрдэм шинжилгээ, сургалт, эмнэл зүйн тусламж үйлчилгээг хослуулан ажиллах, Монгол улсын анагаах ухааны хөгжил, эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудалд чиглэсэн эрдэм шинжилгээний төсөл, суурь судалгаа, цөм технологи, инновацийн ажлыг өндөр түвшинд хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээний ажилтны

мэргэжлийн ур чадвар чадавхийг сайжруулах, салбар хоорондын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг байнга дээшлүүлэхэд оршино.

Зорилго, зорилт, үндсэн чиг үүргээ биелүүлэхэд 6 үндсэн нэгжид анагаах ухааны эрдэмтэн судлаачид 55 жилийн хугацаанд ном, сурах бичиг, гарын авлага, монограф 100 орчим, дууссан ажлын төслийн тайлан 80, шинэ бүтээл 40, шинжлэх ухааны нээлт 2 оновчтой санал, ашигтай загвар 356 гаргаж эрүүл мэндийн салбарт нэвтрүүлсэн байна.

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны төсвийг БСШУЯ, Шинжлэх ухаан технологийн сан (ШУТС)-аас олгож байна.

Санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд УБ хотод Төрийн сан, ШУТС-д нэгтгүүлдэг.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрх зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу АШУҮИС-ийн захирлын 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 27 дугаар тушаалаар АУХ-ийн захирлаар АУ-ны доктор, профессор Б.Мөнхбат томилогдон төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 36 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Acolous 3.0” санхүүгийн программаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Материаллаг байдал:

ТАБ-СТА-А-4 маягтыг ашиглан материаллаг байдлын суурийг 2016 оны Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн зарлагын 1 хувиар сонгов.

Материаллагын байдлыг тогтоохдоо нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул нийт мөнгөн зарлагын 1 хувиар авч үзэх нь чанарын хувьд тохирно гэж үзлээ.

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн зарлага 571.3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 5.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Зургаа. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дотоод хяналт “дунд” байна гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Долоо. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 559.02 сая төгрөгөөр тайлагнагдаж зардлын гүйцэтгэл 99.1 хувьтай байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих эх үүсвэр 5.0 сая төгрөгөөр буюу 100 хувь тасарсан нь тайлант үеийн үр дүн 5.2 сая төгрөгийн алдагдалтай гарахад нөлөөлсөн байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад Тус байгууллага нь өөрийн веб сайтгүй шилэн дансны [/www.shilendans.gov.mn/](http://www.shilendans.gov.mn/) сайтад мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны цахим хуудсанд 20 мэдээллийг оруулахаас 12 мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 88 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 36 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, авлага, өглөгийг мөнгөн сууриар бүртгэснээс санхүүгийн тайлангийн тодруулга буруу тайлагнагдсан, цалин хөлстэй холбогдох дансны бичилтийг холбогдох зааврын дагуу хийгээгүйгээс үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд зөрүүтэй илэрхийлэгдсэн, төслийн зарцуулалтанд холбогдох гэрээ, дүрэм журмыг мөрдөөгүй зэрэг зөрчлүүд байна.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөгийн үлдэгдэл, үндсэн хөрөнгө, орлого, зардал, дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. / ТАБ-СТА-В-3/

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-т нийт 4 төсөл хэрэгжиж байна. 2016 онд эдгээр төсөлд 59.2 сая төгрөгийг төлөвлөснөөс 55.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь нийт зардлын 9.8 хувийг эзэлж байна.

Арван нэг. Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд завсрын аудитыг эхлэх явцад, тус байгууллага нь шилэн дансны аудитад хамрагдахаар Үндэсний аудитын газарт санхүүгийн баримтаа хүргүүлсэн тул завсрын аудит хийгдээгүй.

Арван хоёр. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжөөс төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоо зөв төлөвлөх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн:Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн.

2. “Анагаах ухааны хүрээлэн” нь өөрийн веб сайтгүй, шилэн дансны [/www.shilendans.gov.mn/](http://www.shilendans.gov.mn/) сайтад мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны цахим хуудсанд 20 мэдээллийг оруулахаас 12 мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн:1. Байгууллагын веб сайттай болох

2.Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5.1-д "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна:",5.1.2-т "шилэн дансны бие даасан цэстэй байх; "5.1.4-д "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

3. Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 5.0 сая төгрөгөөр буюу 100% тасалдуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 41.2.1-д" хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

4. Байгууллагын төсвийн төсөлд няравын орон тоог батлуулаагүйгээс нягтлан бодогч нь няравын ажлыг хавсран гүйцэтгэдэг, няравын хариуцан хөтлөх анхан шатны баримтуудыг бүрэн хөтлөөгүй байна.

Шийдвэрлэсэн:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 20.2.11-д "өөрийн шүүд удирдлагын дор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтанд хамруулах арга хэмжээ авах" гэсэн албан шаардлага өгсөн.

5. Тайлант хугацааны цалингийн зардлын дүнг мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнтэй тулган шалгахад санхүүгийн үр дүнгийн тайланд 7.9 сая төгрөгөөр илүү илэрхийлж өглөгийг тодруулга тайланд тайлагнаагүй.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

6. Өмнөх оны 3.1 сая төгрөгийн цалин хөлстэй холбоотой өглөгийн үлдэгдлийг төлснийг ерөнхий журналд илэрхийлсэн боловч мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлд залруулан бүртгэсэн.

7. НДШ-ийн 200.0 мянган төгрөгийн дутуу төлөлтийн дүнг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж тайлагнаагүй.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

8. Цалингийн хүснэгтэд бодогдсон цалингаас суутгасан НДШ-ийг дахин тооцоолоход Энэ нь 1-3 сарын цалинг 3 дугаар сард нь бодож олгохдоо НДШ-ийг 192,000.00 төгрөгөөр хязгаарласнаас 8 ажилтны цалингаас НДШ дутуу, ХХОАТ илүү суутгасан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

9. Цалингийн хүснэгтээр бодогдсон цалингаас суутгасан ХХОАТ-ыг дахин тооцоолоход ажилтнуудад олгосон унаа, хоолны хөнгөлөлтөөс 200.0 төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

10. Цалингийн хүснэгтийн дүнг ерөнхий журналын бичилттэй тулган шалгахад дансны бичилтийг зааврын дагуу бүртгээгүйгээс ерөнхий журналын дүнг 81.4 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

11. Цалингийн хүснэгтийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн дүнтэй тулган шалгахад мөнгөн гүйлгээний тайлангийн дүн 8.5 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

12. Цалингийн хүснэгтийн дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнтэй тулган шалгахад санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнг 600.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

13. Цалингаас суутгасан НДШ-ийг цалингийн тооцооны дансад бүртгэхгүйгээр шууд зардлын дансанд бүртгэснээс ерөнхий журналийн дүн 41.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

14. Цалингаас суутгасан ХХОАТ-ыг цалингийн тооцооны дансад бичилт хийхгүйгээр цалингийн зардалд бүртгэснээс ерөнхий журналийн дүнгээс 35.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

15. Цалингаас суутгасан ҮЭ-ийн татварыг цалингийн тооцооны дансад бичилт хийхгүйгээр шууд зардлын дансад бүртгэснээс ерөнхий журналийн дүнгээс 4.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

16. Төслүүдийн зардлын зарцуулалтыг шалгахад нийт 4 төсөл хэрэгжүүлж, 2016 онд эдгээр төсөлд 59.2 сая төгрөгийг төлөвлөснөөс 55.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Төслийн зардлыг санхүүжүүлэхдээ Төслийн зардлын гүйцэтгэлийн тайланг гэрээний хавсралтаар баталсан Эрдэм шинжилгээний зардлын задаргааны маягтаар гаргуулдаггүй, олгосон зардлыг үндсэн баримтгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн:

1. Эрдэм шинжилгээний зардлын задаргааны маягтаар тайланг гаргуулан, хөрөнгө материалыг хүлээлүүлсэн баримтыг үндэслэн төсөл тус бүрээр хувийн хэрэг хөтлөн тайлагнаж байх.

2. Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолын хавсралт Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-ыг мөрдөж ажиллах албан албан шаардлага өгсөн.

17. Төслийн үйл ажиллагаанд шаардагдах урвалж, багаж хэрэгслийг худалдан авахдаа “ТБОНӨХБАУХА” тухай хуулийг мөрдөөгүй. 2016 онд “Монолаб” ХХК-аас 4 удаагийн худалдан авалтаар 22.6 сая төгрөгийн шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалт хийхдээ, харьцуулалтын арга хэрэглээгүй байна.

Шийдвэрлэсэн:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах ажиллах зөвлөмж өгсөн.

Арван гурав. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

2016 онд 4 төсөлд 55.1 сая төгрөгийг санхүүжүүлэхдээ Төслийн зардлын гүйцэтгэлийн тайланг гэрээний хавсралтаар баталсан Эрдэм шинжилгээний зардлын задаргааны маягтаар гаргуулдаггүй, олгосон зардлыг үндсэн баримтгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.

Арван дөрөв. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудалгүй байна.

Арван тав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэрэгжүүлж дууссан төслүүдэд ашиглаж буй үндсэн хөрөнгүүдийг “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын хөрөнгөд хүлээн авсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Арван зургаа. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 240.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 157.7 сая төгрөгийн алдааг залруулж, 22.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, 60.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

Арван долоо. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Номгон аудит” ХХК гүйцэтгэж төлбөрийн акт, албан шаардлага тогтоогдоогүй, санхүүгийн үйл ажиллагаанд 2 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 50 хувийг хэрэгжүүлж 50 хувийг хэрэгжүүлээгүй байна.

Арван найм. Зөвлөмж

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Арван ес. Зөрчилгүй санал дүгнэлт

“Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан 8 хуудас хавсаргав.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46, Бага тойруу 6

Web: www.audit.mn
УАГ Санхүүгийн аудитын газрын
захирал: Ц.Наранчимэг

Утас: 261663
И-мэйл: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 99117703
И-мэйл: sambuunyamya@audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Ихмонгол хөлөг Аудит” ХХК
Утас: 70001778
Web: www.imkaudit.mn

Захирал: С.Тунгалаг
Утас: 99061771
И-мэйл: tungalag.s@imkaudit.mn

Аудитын менежер
Аудитор: Г.Ариунбат
Утас: 88182081
И-мэйл: ariunbat.g@imkaudit.mn

**“АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” УТҮГ-ЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1:

Өмнөх аудитын зөвлөмжийн талаар

Асуудал 2:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Асуудал 3:

Худалдан авалтын талаар

2016 оны 2 дугаар сарын 15

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Анагаах ухааны хүрээлэн” УТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Өмнөх аудитын зөвлөмжийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	---------------------------

Ажиглалт

1. Өмнөх аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжөөс НДШ, ХХОАТ-ын өр төлбөрийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлж төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоо зөв төлөвлөх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Зөвлөмж

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх./ЭБ,ҮЗ/

/ЭҮ,ТБ, ИБ,Х/

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	---------------------------

Ажиглалт

Тус байгууллага нь өөрийн веб сайтгүй шилэн дансны /shilendans.gov.mn/ сайтад мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны цахим хуудсанд 20 мэдээллийг оруулахаас 12 мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

Эрсдэлүүд

/ИБ,ТБ,Х,ҮЗ/

Зөвлөмж

Байгууллагын веб сайттай болох

Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5.1-д "5.1.Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна:"5.1.2-д"шилэн дансны бие даасан цэстэй байх;"5.1.4-д "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Худалдан авалтын талаар	Тэргүүлэх ач холбогдол № 1
------------------------------------	----------------------------

Ажиглалт

Төслийн үйл ажиллагаанд шаардагдах урвалж, багаж хэрэгслийг худалдан авахдаа ТБОНӨХ бараа ажил үйлчилгээ авах тухай журмыг мөрдөөгүй. 2016 онд Монолаб ХХК-аас 4 удаагийн 22,637,500.00 төгрөгийн худалдан хийхдээ шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтад харьцуулалтын арга хэрэглээгүй байна .

Эрсдэлүүд

/ ҮЗ, ЭҮ, /

Зөвлөмж

ТБОНӨХ бараа ажил үйлчилгээ авах тухай журмыг мөрдөж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

**“АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” УТУГ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	885,870.00	289,927.80
АВЛАГА	-	280,927.80
Бусад авлага	-	280,927.80
Хувь хүмүүсээс авах авлага	-	280,927.80
БАРАА МАТЕРИАЛ	885,870.00	9,000.00
Хангамжийн материал	885,870.00	9,000.00
Бичиг хэргийн материал	-	9,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	153,470,515.69	145,997,267.20
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	153,470,515.69	145,997,267.20
Биет хөрөнгө	152,700,515.69	145,381,267.16
Авто тээврийн хэрэгсэл	33,050,000.00	33,050,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(10,410,750.15)	(13,715,750.19)
Машин, тоног төхөөрөмж	543,499,135.60	554,183,085.25
Хуримтлагдсан элэгдэл	(423,194,923.69)	(435,228,104.83)
Тавилга, аж ахуйн эд хогшил	33,934,594.00	33,934,594.00
Хуримтлагдсан элэгдэл	(24,927,540.07)	(27,592,557.07)
Номын фонд	750,000.00	750,000.00
Биет бус хөрөнгө	770,000.00	616,000.04
Програм хангамж	770,000.00	770,000.00
Хасагдуулга	-	(153,999.96)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	154,356,385.69	146,287,195.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,092,425.68	257,716.39
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,092,425.68	257,716.39
Өглөг	3,092,425.68	257,716.39
Ажиллагчидтай холбогдсон өглөг	3,092,425.68	257,716.39
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	151,263,960.01	146,029,478.61
Засгийн газрын хувь оролцоо	151,263,960.01	146,029,478.61
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	585,204,089.50	585,204,089.50
Өмч: -Төрийн өмч	585,204,089.50	585,204,089.50
Хуримтлагдсан үр дүн	(458,527,435.07)	(463,761,916.47)
Өмнөх үеийн үр дүн	(458,527,435.07)	(458,527,435.07)
Тайлант үеийн үр дүн	-	(5,234,481.40)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,587,305.58	24,587,305.58
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	154,356,385.69	146,287,195.00

“АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	402,993,161.36	569,705,749.65
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,223,161.36	569,705,749.65
Улсын төвлөрсөн төсвөөс	314,465,160.00	564,705,749.65
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	314,465,160.00	554,021,800.00
Хөрөнгийн санхүүжилт	-	10,683,949.65
Нэмэлт санхүүжилтийн орлого	47,503,269.06	5,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	47,503,269.06	5,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	426,909,961.67	574,940,231.05
УРСГАЛ ЗАРДАЛ	421,472,311.66	574,939,193.89
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,472,311.66	574,939,193.89
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	323,037,759.37	422,585,482.36
Цалин	323,037,759.37	422,585,482.36
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,141,932.90	45,879,120.16
Тэтгэврийн даатгалын шимтгэл	34,141,932.90	45,879,120.16
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,357,200.00	8,846,800.00
Гэрэл цахилгааны зардал	920,700.00	3,672,000.00
Түлш, халаалтын зардал	-	3,374,800.00
Цэвэр, бохир усны зардал	436,500.00	1,800,000.00
Хангамж, бараа материалын зардал	6,049,117.76	8,995,870.00
Бичиг хэргийн материал	798,220.00	724,300.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	2,304,274.76	3,905,700.00
Ном, хэвлэлийн зардал	2,000,000.00	3,385,870.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	946,623.00	980,000.00
Нормативт зардал	1,200,000.00	1,000,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,000,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	1,000,000.00
Урсгал засвар	2,500,000.00	1,000,000.00
Томилолт, зочны зардал	11,667,900.00	3,397,600.00
Дотоод томилолтын зардал	2,667,900.00	3,397,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	24,611,300.00	65,077,123.23
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,611,300.00	63,857,723.23
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	1,000,000.00

Даатгалын үйлчилгээний төлбөр	-	59,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	-	60,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	100,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	16,907,101.63	18,157,198.14
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,907,101.63	18,157,198.14
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.01	1,037.16
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.01	1,037.16
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.01	1,037.16
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(23,916,800.31)	(5,234,481.40)
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(23,916,800.31)	(5,234,481.40)

**“АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи**

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	361,968,429.06	571,305,913.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,807,915.00
Нийтлэг татварын бус орлого	-	3,807,915.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	3,807,915.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,807,915.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	361,968,429.06	567,497,998.00
Улсын төвлөрсөн төсвөөс	314,465,160.00	554,021,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	314,465,160.00	554,021,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	47,503,269.06	5,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	47,503,269.06	5,000,000.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	8,476,198.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	8,476,198.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	361,968,429.06	571,305,913.00
УРСГАЛ ЗАРДАЛ	361,968,429.06	571,305,913.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,968,429.05	571,304,875.84
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	285,397,250.38	433,841,588.37
Үндсэн цалин	278,467,250.38	433,841,588.37
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	28,435,283.91	46,214,849.24
Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,095,180.66	29,409,449.51
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,068,020.65	3,361,079.95
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,585,025.81	4,201,349.93
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	517,005.17	840,270.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,170,051.62	8,402,699.85
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	1,357,200.00	8,846,800.00
Гэрэл цахилгааны зардал	920,700.00	3,672,000.00
Түлш, халаалтын зардал	-	3,374,800.00
Цэвэр, бохир усны зардал	436,500.00	1,800,000.00
Хангамж, бараа материалын зардал	5,799,494.76	8,119,000.00
Бичиг хэрэг	798,220.00	733,300.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,304,274.76	3,905,700.00
Ном, хэвлэл	2,000,000.00	2,500,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	697,000.00	980,000.00
Нормативт зардал	1,200,000.00	1,000,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,000,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	1,000,000.00
Урсгал засвар	2,500,000.00	1,000,000.00
Томилолт, зочны зардал	11,359,200.00	3,397,600.00
Дотоод албан томилолт	2,359,200.00	3,397,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,920,000.00	65,077,123.23

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	24,920,000.00	63,857,723.23
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,000,000.00
Даатгалын үйлчилгээ	-	59,400.00
Тээврийн хэрэгслийн татвар		60,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо		100,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	3,807,915.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	3,807,915.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.01	1,037.16
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.01	1,037.16
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.01	1,037.16

“АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	(458,527,435.07)	-	151,263,960.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	(458,527,435.07)	-	151,263,960.01
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			(5,234,481.40)	-	(5,234,481.40)
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	(463,761,916.47)	-	146,029,478.61

**“АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” УТУГ
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

/төгрөгөөр/

	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	559,021,800.00	554,020,762.84	(5,001,037.16)	99%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	559,021,800.00	554,020,762.84	(5,001,037.16)	99%
Бараа, үйлчилгээний зардал	559,021,800.00	554,020,762.84	(5,001,037.16)	99%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,267,600.00	425,365,390.37	(3,902,209.63)	99%
Үндсэн цалин	429,267,600.00	425,365,390.37	(3,902,209.63)	99%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,219,400.00	46,214,849.24	(1,004,550.76)	98%
Тэтгэврийн даатгал	30,048,927.28	29,409,449.51	(639,477.77)	98%
Тэтгэмжийн даатгал	3,434,254.54	3,361,079.95	(73,174.59)	98%
ҮОМШӨ ний даатгал	4,292,618.18	4,201,349.93	(91,268.25)	98%
Ажилгүйдлийн даатгал	858,363.63	840,270.00	(18,093.63)	98%
Эрүүл мэндийн даатгал	8,585,236.37	8,402,699.85	(182,536.52)	98%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,846,800.00	8,846,800.00	-	100%
Гэрэл цахилгаан	3,672,000.00	3,672,000.00	-	100%
Түлш, халаалт	3,374,800.00	3,374,800.00	-	100%
Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,800,000.00	-	100%
Хангамж, бараа материалын зардал	8,099,000.00	8,119,000.00	20,000.00	100%
Бичиг хэрэг	733,300.00	733,300.00	-	100%
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,905,700.00	3,905,700.00	-	100%
Ном, хэвлэл	2,500,000.00	2,500,000.00	-	100%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	960,000.00	980,000.00	20,000.00	102%
Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100%
Нормын хувцас зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	-	100%
Эд хогшил худалдан авах	1,000,000.00	1,000,000.00	-	100%
Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100%
Томилолт, зочны зардал	3,511,100.00	3,397,600.00	(113,500.00)	97%
Дотоод албан томилолт	3,511,100.00	3,397,600.00	(113,500.00)	97%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	60,077,900.00	60,077,123.23	(776.77)	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,858,500.00	58,857,723.23	(776.77)	100%
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100%
Даатгалын үйлчилгээ	59,400.00	59,400.00	-	100%
Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00	-	100%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	100,000.00	-	100%

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	559,021,800.00	554,020,762.84	(5,001,037.16)	99%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	554,021,800.00	554,020,762.84	(1,037.16)	100%
Улсын төсвөөс санхүүжих	554,021,800.00	554,020,762.84	(1,037.16)	100%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	-	(5,000,000.00)	0%
Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	-	(5,000,000.00)	0%
АЖИЛЛАГСДЫН ТОО	46	46	-	100%
Удирдах ажилтан	1	1	-	100%
Гүйцэтгэх ажилтан	39	39	-	100%
Үйлчлэх ажилтан	6	6	-	100%